

АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Нийтийн биеийн тамирын арга хэмжээ:

Биеийн тамир спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, Монгол улсын их хурлын 52 дугаар тогтоол “Алсын хараа-2050” зорилт 3.5.1, Монгол улсын Ерөнхийлөгчийн “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн зэрэг заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Биеийн тамир спортын хорооноос улсын хэмжээнд 2024 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр “Бүх нийтийн гүйлт”-ийг зохион байгуулах чиглэл өгсөний дагуу уг арга хэмжээнд нийт 200 гаруй иргэд хамрагдсан.

“Би сэлж сурлаа-II” сургалтын аян 3 сарын богино хэмжээний түргэвчилсэн сургалт 2024 оны 9 сарын 20-оос эхлэн 12 сарын 20-ыг хүртэл үргэлжилэх бөгөөд нийт 130 хүүхэд хамрагдав.

Нийтийн биеийн тамирын 32 арга хэмжээг 114 аж ахуй нэгж, албан байгууллагын дунд зохион байгуулан 8385 хүүхэд, залуучууд, иргэд, хөдөлмөрчид хамрагдсан байна.

Улсын аварга, Бүсийн нэрэмжит, ААШ шалгаруулах тэмцээн:

Бодибилдинг фитнесийн 57дахь удаагийн бүх Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн, “Ulaanbaatar Pro” Олон улсын Жюү-Жицү бөхийн тэмцээн, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Алтан эмээл хотод зохион байлагдсан жүдо бөхийн тэмцээн, Улсын аварга шалгаруулах 2 тэмцээн, Үндэсний сурын Улсын отго харваа болон төвийн бүсийн харваанд тамирчиддаа хамруулсан.

Мөн орон нутагтаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор жил бүр зохион байгуулагддаг 21 аймгийн аварга шалгаруулах хөл бөмбөгийн тэмцээн, “Эхлэл” клубын 20 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан олон улсын таеквондогийн зүүн бүсийн тэмцээнүүдийг зохион байгуулав.

Хамтарсан бэлтгэл сургуулилт, сургалт:

Монгол Улсын Мэргэн Л.Одсайханаар ахлуулсан Сүхбаатар аймгийн Үндэсний сурын холбооны харваачид Цонжин болдог Ультрасоник амралтын газар Үндэсний их баяр наадмын бэлтгэлд гарсан.

Ирэн улсын мэргэжилтэн Монгол улсын шигшээ багийн дасгалжуулагч, Натур Мед талон клубын ахлах дасгалжуулагчын удирдлаган дор волейболын өсвөрийн шигшээ багийн тамирчид 12 хоногийн бэлтгэл сургуулилт хийв.

Монголын хөл бөмбөгийн холбоотой хамтран мэргэшүүлэх шүүгчийн сургалтыг 4 өдрийн турш зохион байгуулан ажиллаа.

2024 оны 09 дүгээрс сарын 09-ны өдрөөс монгол бичгийн багшаар Үндэсний бичгийн анхан шатны сургалтыг 7 хоногийн даваа, лхавга, баасан гаригууд 1 цагийн сургалтыг тогтмол авч, 7 хоног бүрийн даваа гариг бүр уншлага, хуулан бичгийн цагтай болсон.

Дотоод үйл ажиллагаа:

2024 оны 07 дугаар сарын 21-нд “Спорт цогцолбор”-ын нээлтийн үйл ажиллагаагаа хийж, нээлтэнд зориулж Sukhbaatar one draem - “Modum wolvels” багийн өсвөр үеийн сагсан бөмбөгийн тоглолт, Сэлэнгэ бодонс - Сүхбаатар аймгийн насанд хүрэгчдийн шигшээ” багийн сагсан бөмбөгийн тоглолт, “Натур мед толун” - “Сүхбаатар аймгийн Волейболын шигшээ” багийн нөхөрсөг тоглолтуудыг зохион байгуулав.

Улаанбаатар хотын “Сөүл сонгдо эмнэлэг”-ийг сонгон байгууллага хамт олноороо урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээний багц гаргуулан үзлэг шинжилгээнд хамрагдаж, эрүүл мэнддээ хөрөнгө оруулалт хийлээ. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багц шинжилгээнд эмчийн үзлэг болон багажийн шинжилгээгээр аливаа өвчний шинж тэмдэг, ирээдүйд учирч болох эрүүл мэндийн эрсдэлээс сэргийлж ажиллаа.

Монголын тамирчидын баярын өдрийг тохиолдуулан ахмад ажилтан Оросоогийн Баатархуягийг алдаршуулах үйл ажиллагааг хамт олон зохион байгуулаж ажилчин албан хаагчийн дунд хөгжөөнт буухиа тэмцээнийг мөн зохион явуулсан ба ажилчин албан хаагчийн хүүхдүүдийн дунд 06-10 насны дунд “Миний гэр бүл”, 11-15 насны дунд “Миний дуртай спорт” ангилалаар гар зургийн уралдааныг зохион байгуулаж, энхий 3 байрыг шалгаруулав.

Найлах дүүргийн Тайж хайрхан уулын энгэрт Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Биеийн тамир, спортын улсын хороо, Соёл урлагийн газраас хамтран зохион байгуулсан “Нүүдэлчин-2024” Дэлхийн соёлын фестиваль 2024 оны 08 дугаар сарын 16-18 хооронд зохион байгуулагдав.

Тус фестивальд аймгийн Биеийн тамир спортын газраас 8 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй оролцсон. /Байгууллагын дарга, биеийн тамирын хэлтсийн дарга, нягтлан бодогч, хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн, үндэсний бөхийн дасгалжуулагч, усан спортын дасгалжуулагч, нярав, үйлчлэгч/

Энэ удаагийн фестивальд дотоодын 483, гадаад улсын 11 үзэгч, зочидод байгууллагын танилцуулга, орон нутгийн онцлог шинж, уламжлалт спортын төрөл, хөгжил, түүх, соёлоо сурталчлан түгээж, соёлын биет бус өвийн зарим нэг төрлийг дэлгэн харуулахаас гадна төрөн гарсан тамирчид, алдартанууд танилцуулах ажлын зохион байгуулав.

Сүхбаатар аймгийн Асгат сумын харъяат “Парис 2024” паралимпын наадмын таеквондогийн төрөлд мөнгөн медаль хүртсэн МУГТ Ганбатын Болор-эрдэнийг багш, дасгалжуулагчийн хамт хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. Мөн Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын харъяат Токио-2020, Парис-2024 олимпийн хүндийн өргөлтийн шүүгчээр ажилласан, Олон улсын хүндийн өргөлтийн холбооны 1-р зэрэг, Олимпийн зэрэглэлийн шүүгч Л. Одгэрэлд Биеийн тамир спортын газар хүндэтгэл үзүүлэв.

Усан спорт чийрэгжүүлэлтийн төвийн усан сангийн ариутгал халдваргүйжүүлэлтн үйл ажиллагаанд 65кг 1,072,500 төгрөгийн ариутгалын бодис, 7ширхэг 385,000төгрөгийн ус тунгалагжуулагч, РН хасах бодис 3ширхэг 198,000 төгрөгийн бодис нийт 1,655,000 төгрөгийн бодис тус тус зарцуулсан байна.